

NSW мужийн Боловсролын Яам

Бүрэн хичээлийн ирц чухал үүрэгтэй



Сургуульд өдөр бүр хамрагдан суралцсанаар таны хүүхэд өндөр эрдэм мэдлэгийг эзэмшиж ингэснээр ирээдүйн амьдрал, ажил мэргэжлээ зөв сонгох боломжийг олох болно.

Сургуульд тогтмол хамрагдах нь таны хүүхдийн суралцах чадварыг дээшлүүлж, үе тэнгийнхэнтэйгээ эерэг харилцаа тогтооход тусална.

Хэрэв танд хүүхдээ сургуульд явуулахад ямар нэгэн дэмжлэг хэрэгтэй бол бидэнтэй холбогдоно уу.

Сургуультай холбогдоход орчуулагчийн тусламж хэрэгтэй бол 131 450 дугаарт холбогдож, операторт ямар хэлээр ярьдагаа хэлж, сургууль руу холбож өгөхийг хүснэ үү. Оператор шугаманд орчуулагч оруулж ирэн танд туслах бөгөөд энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.

